



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ ТӨРИЙН ӨМЧИТ
АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД:СНАГ-2025/61/НА-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: М.Лхагвасүрэн
Утас: 261628 Цахим хаяг: lkhagvasurenm@audit.gov.mn
Ашиг баланс аудит ХХК-ийн захирал: Л.Майцэцэг
Утас: 99081568 Цахим хаяг: ashidbalance@gmail.com

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсралтны аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсралтны аудитын талаар	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага	16
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ШТШАБ	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чинглэй дүүрэг, Улаанбаатар хот, 15180
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ШИНГЭН ТУЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ
БАЙГУУЛАМЖ ТӨААТАҮГ-ЫН
ЗАХИРАЛ Г.ГАНСҮХ ТАНАА

2025.03.14 № 07/1024
таний -ны № -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТАҮГ-ЫН 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайллан, болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бурдсэн санхүүгийн тайланд аудит хийлзээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн Газрын тосны бүтээгдэхүүн худалдах, худалдан авах тухай гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулаагүй зөрчил нь шинж чанаарын хувьд материаллаг, дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 40.2.2, 48 дугаар зүйлийн 48.2.11 дэх заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих төлөвлөгөө 382.1 сая төгрөг буюу 38.9 хувиар тасарсан нь импортлогч байгууллагуудын Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас авах газрын тосны бүтээгдэхүүний хэмжээ буурсан, Лекс ойл ХХК нь ижил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой шилжүүлэн ачилтын тоо багассан нь нөлөөлжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТУГ нь тайлант онд нийт 4,022.6 сая төгрөгийн орлого бурдүүлж, 3,162.9 сая төгрөгийн зардал гарган, 859.7 сая төгрөгийн ашигтай байхаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 12,470.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 10,082.1 сая төгрөгийг зарцуулж, 2,388.4 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажилласан байна. Төрийн өмчийн ногдол ашиг 347.2 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд нийт 9 компанийтай гэрээ байгуулж 17,990 тонн ачааг хадгалж, 36,650.5 тонн ачааг шилжүүлсэн, чанарын хяналтын сорилт, шинжилгээний ажил гүйцэтгэх гэрээг 10 компанийтай байгуулан газрын тосны бутээгдэхүүний 99 дээжид чанар хяналтын шинжилгээ хийсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлэх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТИН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Балансын үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	/төгрөгөөр/ 2024 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	2,557,770,209.49	4,583,513,804.42
1.1.2	Дансны авлага	38,865,110.94	707,809,747.40
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	157,967,450.66	3,014,224.22
1.1.4	Бусад авлага	131,530,862.31	307,609,824.39
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	6,416,108,774.02	6,080,877,606.75
1.1.6	Бараа материал	271,266,746.21	234,536,215.28
1.1.7	Урьдчилж төлсөн зардал	18,000,000.00	18,000,000.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	9,591,509,153.63	11,935,361,422.46
1.2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
1.2.1	Үндсэн хөрөнгө	12,813,376,537.06	12,424,677,862.18
1.2.2	Биет бус хөрөнгө	1,368,360,392.31	1,293,450,876.46
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	95,475,488.61	85,259,842.85
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,277,212,417.98	13,803,388,581.49
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	23,868,721,571.61	25,738,750,003.95
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	3,842,899.12	-
2.1.1.3	Татварын өр	-	5,162,668.79
2.1.1.7	Урьдчилж орсон орлого	131,530,862.31	306,163,796.45
2.1.1.9	Нөөц	-	3,909,977.30
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	135,373,761.43	315,236,442.54
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	124,669,700.20	23,043,218.19
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	124,669,700.20	23,043,218.19
2.2	Өр төлбөрийн нийт дүн	260,043,461.63	338,279,660.73
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: Төрийн	15,362,339,049.32	15,362,339,049.32
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	533,483,446.52	533,483,446.52
2.3.9	Хуримтлагдсан ашиг	7,712,855,614.14	9,504,647,847.38
	Эздийн өмчийн дүн	23,608,678,109.98	25,400,470,343.22
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	23,868,721,571.61	25,738,750,003.95

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн
газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого/цэвэр/	2,852,260,202.20	11,634,720,544.78
2	Борлуулалтын өртөг	-	7,454,824,160.09
3	Нийт ашиг/алдагдал/	2,852,260,202.20	4,179,896,384.69
5	Хүүгийн орлого	863,614,638.96	669,071,926.99
8	Бусад орлого	773,737.22	166,715,454.90
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,351,341,734.24	2,485,563,973.43
12	Бусад зардал	180,200.00	176,200.00
13	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз(гарз)	(67,033,944.84)	-
14	Бусад ашиг/алдагдал	(7,110,000.00)	(141,504,777.35)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал/	1,290,982,699.30	2,388,438,815.80
19	Орлогын татварын зардал	133,695,657.14	249,534,848.01
20	Тайлант үеийн ашиг/алдагдал/	1,157,287,042.16	2,138,903,967.79

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуимтлагдсан ашиг /алдагдал	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	15,362,339,049.32	535,186,521.93	7,209,214,411.98	23,106,739,983.23
Залруулсан үлдэгдэл	15,362,339,049.32	535,186,521.93	7,209,214,411.98	23,106,739,983.23
Тайлант үеийн ашиг, алдагдал	-	-	1,157,287,042.16	1,157,287,042.16
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	73,181,740.00	-	73,181,740.00
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	15,362,339,049.32	533,483,446.52	7,712,855,614.14	23,608,678,109.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	74,378.10	74,378.10
Залруулсан үлдэгдэл	15,362,339,049.32	533,483,446.52	7,712,929,992.24	23,608,752,488.08
Зарласан ногдол ашиг	-	-	347,186,112.65	347,186,112.65
Тайлант үеийн ашиг, алдагдал	-	-	2,138,903,967.79	2,138,903,967.79
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	15,362,339,049.32	533,483,446.52	9,504,647,847.38	25,400,470,343.22

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,128,320,980.47	24,597,851,440.76
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,100,021,712.47	12,312,057,710.20
1.1.6	Бусад мөнгөн орлого	3,028,299,268.00	12,285,793,730.56
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	8,261,489,839.86	22,655,724,647.50
1.2.1	Ажиллагчдад төлсөн	998,900,998.90	1,105,289,917.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	279,256,598.60	319,053,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	23,751,907.00	8,235,532,000.32
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	74,520,405.69	76,076,692.46
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	141,421,680.50	54,193,210.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	476,378,867.12	721,748,222.15
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	342,225.00	118,800.00
1.2.9	Бусад мөнгөн зардал	6,266,917,157.05	12,143,712,805.57
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,133,168,859.39)	1,942,126,793.26
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	863,614,638.96	669,071,926.99
2.1.	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	863,614,638.96	669,071,926.99
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	366,111,096.08	238,269,012.67
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	312,076,368.81	237,768,387.22
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	54,034,727.27	500,625.45
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	497,503,542.88	430,802,914.32
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	653,645,840.00	347,186,112.65
3.2.1	Төлсөн ногдол ашиг	653,645,840.00	347,186,112.65
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(653,645,840.00)	(347,186,112.65)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,289,311,156.51)	2,025,743,594.93
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,847,081,366.00	2,557,770,209.49
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,557,770,209.49	4,583,513,804.42

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчтөг аж ахуйн тооцоот үйлдвэрийн
газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэм жих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 оны		Харьцуулалт	
				Төлөв лөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт, борлуулалт							
1	Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих	тонн	60,768.3	72,000.0	36,650.5	(35,349.5)	50.9
	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах	тонн	10,575.9	8,600.0	17,990.0	9,390.0	209.2
	Газрын тосны бүтээгдэхүүний бөөний борлуулалт хийх	тонн	-	5,000.0	2,642.1	(2,357.9)	52.8
2	Нийт орлого	мян/төг	3,716,648.6	4,022,577.0	12,470,507.9	8,447,930.9	310.0
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян/төг	2,852,260.2	3,692,577.0	11,634,720.5	7,942,413.5	315.1
	Дансны хүү, бусад орлого	мян/төг	864,388.4	330,000.0	835,787.4	505,787.4	253.3
3	Нийт зардал	мян/төг	2,425,665.9	3,067,355.8	10,082,069.1	7,014,713.3	328.7
	Үүнээс: Удирдлагын зардал	мян/төг	475,153.3	534,844.0	519,151.0	(15,693.0)	97.1
4	Татварын өмнөх ашиг	мян/төг	1,290,982.7	955,221.2	2,388,438.8	1,433,217.6	250.0
5	Цэвэр ашиг/алдагдал	мян/төг	1,157,287.0	859,669.1	2,138,904.0	1,279,234.9	248.8
6	Төсвийн төлбөрт	мян/төг	554,911.2	805,033.8	1,040,801.2	235,767.4	129.3
	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	мян/төг	55,000.0	95,522.1	207,140.1	111,618.0	216.9
	Нэмэгдсэн өргтийн албан татвар	мян/төг	233,322.3	369,257.7	386,884.2	17,626.5	104.8
	Тээврийн хэрэгслийн татвар	мян/төг	241.2	700.0	340.7	(359.3)	48.7
	Нийгмийн даатгалын шимтгэл	мян/төг	156,605.4	197,626.7	319,053.0	121,426.3	161.4
	Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян/төг	9,357.4	14,000.0	9,357.4	(4,642.6)	66.8
	Хувь хүний орлогын албан татвар	мян/төг	98,013.7	126,327.3	115,471.7	(10,855.6)	91.4
7	Бусад татвар	мян/төг	2,371.2	1,600.0	2,554.1	954.1	159.6
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	34	38	35	30 (3.0)	92.1

**Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчтэй аж ахуйн тооцоот үйлдвэрийн
газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

9	Нийт цалингийн сан	мян/төг	1,164,750.9	1,463,901.8	1,318,301.8	(145,600.0)	90.1
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян/төг	2,854.8	3,210.3	3,138.8	(71.5)	97.8
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян/төг	0.65	0.76	0.81	0.0	106.0
12	Хөрөнгө оруулалт	мян/төг	366,111.1	477,030.0	238,269.0	(238,761.0)	49.9
13	Нийт авлага	мян/төг	328,363.5	-	1,018,433.8	1,018,433.8	-
14	Нийт өглөг	мян/төг	128,512.6	67,940.1	338,729.6	270,339.5	497.9
	Үүнээс: Богино хугацаат өр төлбөр	мян/төг	3,842.9	5,000.0	315,236.4	310,236.4	6,304.7
	Үрт хугацаат өр төлбөр	мян/төг	124,669.7	62,940.1	23,042.2	(39,896.9)	36.6

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Төмөр замаар тээвэрлэн нийлүүлж байгаа газрын тосны бүтээгдэхүүнийг Монголын вагон цистерн болон автоцистеринд шилжүүлэн ачих, хадгалах, үйл ажиллагааг тасралтгүй явуулах, газрын тосны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, цаашид тус байгууламжийн ашиглалтыг мэргэжлийн удирдлагаар хангах” гэж тодорхойлсон байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Газрын тосны бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих, хадгалах, ажлыг гүйцэтгэх;
- Газрын тосны бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллээр холбогдох байгууллагыг хангах;
- Олон улсын чанарын стандартад нийцсэн газрын тосны бүтээгдэхүүнийг зохих журмын дагуу импортлох;
- Газрын тосны бүтээгдэхүүний чанарт шинжилгээ хийх
- Үйлдвэрийн газар нь хөрөнгө оруулалт хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, судалгаа хийх;
- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах; хяналт тавих;
- Хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх;

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨААТҮГ гэсэн статустай, өмчийн 100.0 хувийг төр эзэмшиж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ нь Засгийн газрын 2009 оны 347 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөреөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах ...” гэсэн заалттай нийцэж байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ нь төлөөлөн удирдах зөвлөлгүй байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын багц хуулиуд, Компанийн тухай хуульд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд ТӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Нягтлан болох бүртгэлийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Тогтвортой байдлын тухай хууль;
- Төрийн болон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Авлигын эсрэг хууль;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

**Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн
газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын захирлын 2019 оны А/04 дугаар тушаалаар дотоод хяналт шалгалтын журмыг баталж, мөрдөн ажиллаж байна. Дотоод хяналтын ажилтан нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажилтны ажлыг хавсрان гүйцэтгэж байна. Тайлант онд 4 чиглэлээр 17 төрлийн ажил гүйцэтгэхээр төлөвлөгөө гаргаж, ТӨААТҮГ-ын захирлаар батлуулан, биелэлтийг 94.5 хувьтай гэж тайлагнасан байна.

Дотоод аудитын ажилтны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын захирлын 2024 оны А/26 дугаар тушаалаар шинэчлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь шинээр батлагдсан холбогдох хууль тогтоомж болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,870.1 сая төгрөгөөр буюу 7.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,557,770.2	4,583,513.8	2,025,743.6
Дансны авлага	38,865.1	707,809.7	668,944.6
Бусад авлага	131,530.9	307,609.8	176,078.9
Татвар, НДШ авлага	157,967.5	3,014.2	(154,953.7)
Бусад санхүүгийн хөрөнгө	6,416,108.8	6,080,877.6	(335,231.2)
Бараа материал	271,266.7	234,536.2	(36,730.5)
Урьдчилж төлсөн зардал	18,000.0	18,000.0	-
Үндсэн хөрөнгө	14,277,212.4	13,803,388.6	(473,823.8)
Нийт хөрөнгө	23,868,721.6	25,738,750.0	1,870,028.4
Богино хугацаат өглөг	3,842.9	-	(3,842.9)
Татварын өр төлбөр	-	5,162.7	5162.7
Урьдчилж орсон орлого	131,530.9	306,163.8	174,632.9
Нөөц, өр төлбөр	-	3,910.0	3,910.0
Урт хугацаат өр төлбөр /Хойшлогдсон татварын өр/	124,669.7	23,043.2	(101,626.5)
Эздийн өмч	23,608,678.1	25,400,470.3	1,791,792.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	23,868,721.6	25,738,750.0	1,870,028.4

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бусад санхүүгийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүн данстууд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,025.7 сая төгрөгөөр өссөн нь газрын тосны бүтээгдэхүүний борлуулалтын орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Дансны авлагын үлдэгдэл 707.8 сая төгрөг болж 668.9 сая төгрөгөөр өссөн нь газрын тосны бүтээгдэхүүн хадгалалтын үйлчилгээ, борлуулалтын авлага, хугацаандаа төлөөгүй алданги тооцсон нь нөлөөлсөн байна.

Бусад авлага дансны үлдэгдэл 307.6 сая төгрөг болсон нь арилжааны банкнуудад байршуулсан хадгаламжийн хүүгийн авлагыг бүртгэсэнтэй холбоотой байна.

Бусад санхүүгийн хөрөнгө дансны үлдэгдэл 6,080.9 сая төгрөг болж 335.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд Хас банкны 276.9 сая төгрөг, Төрийн банкны 2,139.2 сая төгрөг, Худалдаа хөгжлийн банкны 4,000.0 сая төгрөгийн хадгаламжийн дансыг тус тус хааж, Голомт банканд 3,000.0 сая, Төрийн банканд 3,000.0 сая төгрөгийн хугацаатай хадгаламж шинээр нээсэнтэй холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл 234.5 сая төгрөг болж 36.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд бараа материал актальсантай холбоотой байна.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэлд аудитын төлбөр 18.0 сая төгрөгийг бүртгэсэн байна.

Эргэлтийн бус хөрөнгийн үлдэгдэл 13,803.4 сая төгрөг болж 473.8 сая төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Тайлант онд 155.2 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан;
- Машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл их засварын зардал 82.5 сая төгрөгөөр капиталжуулж бүртгэсэн ;
- Татварын авлага данснаас хойшлогдсон татварын хөрөнгө дансанд 8.2 сая төгрөгийг шилжүүлж, 18.4 сая төгрөгийг бууруулж бүртгэсэн;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны А-1/2465 дугаар албан бичгээр элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй 6 нэр төрлийн 3.3 сая төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан;
- Акталж, данс бүртгэлээс хасагдсан хөрөнгийн хорогдол 78.7 сая, тайлант онд 626.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцонтой тус тус холбоотой байна.

Богино хугацаат өглөг 3.8 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны жилийн эцсээр үүссэн цахилгааны төлбөрийг төлж барагдуулсан байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 306.2 сая төгрөг болсон нь арилжааны банкнуудад байршуулсан хадгаламжийн гэрээнд заасан хугацааны хүүгийн орлогыг урьдчилж орсон орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Нөөц өр төлбөр дансны үлдэгдэл 3.9 сая төгрөг болсон нь төмөр замын бетон дэр сольсон ажлын баталгаат хугацааны өр төлбөрийн үлдэгдэл байна.

Хойшлогдсон татварын өр дансны үлдэгдэл 23.0 сая төгрөг болж 101.7 сая төгрөгөөр буурсан нь ААНОАТ-ын тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлд элэгдэл тооцоогүй зөрүү дүнгээр хойшлогдсон хөрөнгө дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 25,400.5 сая төгрөг болж 1,791.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацааны цэвэр ашиг 2,138.9 сая төгрөг, ногдол ашиг 347.1 сая төгрөгийг төлсөн нь нөлөөлсөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

**Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн
газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын захирал нь байгууллагын эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 705 дугаар тогтоолоор Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 4,022.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 3,067.4 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 859.7 сая төгрөг байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын 20 арга хэмжээнд 477.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 12,470.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 10,082.1 сая төгрөгийн зардал гарган, 2,388.4 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашиг, 249.5 төгрөг татварын зардал, 2,138.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023 он Гүйцэтгэл	2024 он		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт борлуулалт							
1	Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих	тонн	60,768.3	72,000.0	36,650.5	(35,349.5)	50.9
	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах	тонн	10,575.9	8,600.0	17,990.0	9,390.0	209.2
	Газрын тосны бүтээгдэхүүн ий бөөний борлуулалт хийх	тонн	-	5,000.0	2,642.1	(2,357.9)	52.8
2	Нийт орлого	мян.төг	3,716,648.6	4,022,577.0	12,470,507.9	8,447,930.9	310.0
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	2,852,260.2	3,692,577.0	11,634,720.5	7,942,413.5	315.1
	Дансны хүү, бусад орлого	мян.төг	864,388.4	330,000.0	835,787.4	505,787.4	253.3
3	Нийт зардал	мян.төг	2,425,665.9	3,067,355.8	10,082,069.1	7,014,713.3	328.7
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	475,153.3	534,844.0	519,151.0	(15,693.0)	97.1
4	Татварын өмнө ашиг	мян.төг	1,290,982.7	955,221.2	2,388,438.8	1,433,217.6	250.0
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	1,157,287.0	859,669.1	2,138,904.0	1,279,234.9	248.8
6	<u>төсвийн төлбөрт нийт дүн</u>	мян.төг	554,911.2	805,033.8	1,040,801.2	235,767.4	129.3
7	Хөрөнгө оруулалт	мян.төг	366,111.1	477,030.0	238,269.0	(238,761.0)	49.9

Нийт орлогын гүйцэтгэл 12,470.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 8,447.9 сая төгрөг буюу 3 дахин нэмэгдсэн нь газрын тосны бүтээгдэхүүний бөөний борлуулалт хийгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 10,082.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 7,014.7 сая төгрөг буюу 3 дахин нэмэгдсэн байна. Энэ нь газрын тосны бүтээгдэхүүний өртөг, цалин хөлс, нийгмийн даатгал, ашиглалтын зардал, засвар үйлчилгээний зардал нэмэгдэж, шатахуун, үндсэн

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн
газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

хөрөнгийн элэгдэл, бичиг хэрэг, хөдөлмөр хамгааллын зардал, шуудан холбооны зардал
батлагдсан төлөвлөгөөнөөс дутуу зарцуулсан нь нөлөөлжээ.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний
дагуу 14 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 238.3 сая төгрөгийн зардлыг
санхүүжүүлжээ.

Тайлант онд цэвэр ашиг 2,138.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,279.2 сая төгрөгөөр илүү
байгаа нь зардлын хэмнэлт, орлого өссөнтэй холбоотой байна.

ТӨБЗГ-ЫН 2024 ОНЫ 7 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДРИЙН 351 ДҮГЭР ТОГТООЛООР Шингэн түлш
шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
ТЭНЦЛИЙН ЦЭВЭР АШГИЙН ДҮНГЭЭС Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох
хувьцааны ногдол ашгийг 347.1 сая төгрөгөөр тогтоосныг улсын төсөвт төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дунд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн үйл ажиллагааг сайжруулах анхан шатны баримтын иж бүрдлийг хангаагүй гүйлгээг бүртгэхгүй байх, шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн байршуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ашид баланс аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Алтанцэцэг, туслах аудитор Б.Амаржаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Л.Оюунчимэг, компанийн захирал Л.Майцэцэг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү, нийцлийн аудитын газрын аудитор М.Лхагвасүрэн, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлангаа Ашид баланс аудит ХХК-д 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 2,425.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 24.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ажлын ачааллыг нягтруулж, 3 орон тоо дутуу ажилласнаар цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл зэрэг ажиллагсадтай холбоотой зардал, тогтмол зардлыг 440.1 сая төгрөг буюу 14.4 хувиар хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ТӨБЗГ-ын 2023 оны 705 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 477.0 сая төгрөг, газрын тосны бүтээгдэхүүн худалдан авах төлөвлөгөөг 11,980.0 сая төгрөгөөр тус тус баталсан байна. Тайлант хугацаанд тендер шалгаруулалт зохион байгуулж 3.1 сая литр дизель түлшийг 8,200.3 сая төгрөгөөр худалдан авсан. Хөрөнгө оруулалтын зориулалтаар албан тушаалын 1 орон сууцны байрыг 141.5 сая төгрөг, төмөр замын модон дэр солих засварын ажил 127.1 сая төгрөг, тавилга эд хогшил, компьютер 13.1 сая төгрөгөөр тус тус худалдан авсан. Албан конторын барилга, галын

дохиоллын тоног төхөөрөмжийн засвар ажил үйлчилгээтэй холбоотой тендер зарласан
боловч амжилтгүй болсон байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор
баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг
тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд
холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр
нелөөг харгалзан 26 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод
байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ нь Шилэн дансны цахим хуудсанд нийт
127,779.8 сая төгрөгийн 249 мэдээлэл байршуулахаас орлогын 50.6 сая төгрөгийн 3
мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой,
иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар
зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо
хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш
үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга,
хүлээн авагчийн нэр" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, Санхүүгийн тайлангийн
аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд, иж бүрэн,
үнэн зөв байршуулж байх зөвлөмж өгсөн.

4.5 Завсрыйн аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрыйн аудитын талаар

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2024 оны 3 дугаар улирлын
санхүүгийн тайланд хийсэн завсрыйн аудитаар бараа материал, бүтээгдэхүүний
борлуулалтын орлого, хадгаламжийн дансны хүүгийн орлого, нийт зардлын данстуудад
горим, сорил хэрэгжүүлсэн.

Тус үйлдвэрийн газар нь газрын тосны бүтээгдэхүүн 1,311.9 сая төгрөгийн худалдан авалт,
ибаримтгүй, 2,717.1 сая төгрөгийн борлуулалтын орлого, 99.8 сая төгрөгийн харилцах данс,
хадгаламжийн хүүгийн орлого, нийт 2,816.9 сая төгрөгийн борлуулалтыг тайлагнаагүй, 27.1
сая төгрөгийн цахилгааны төлбөр анхан шатны баримтгүй зэрэг нийт 4,155.9 сая төгрөгийн
зөрчлийг илрүүлж асуудлын бүртгэлээр баталгаажуулсныг жилийн эцсийн аудитаар дахин
хянахад 4,155.9 сая төгрөгийн зөрчлийг запруулж нөхөж тайлагнасан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах 1 зөвлөмж өгснөөс
бүрэн хэрэгжсэн байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	1	-	1	-	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитаар дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 43.9 сая төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Арилжааны банкны хадгаламжийн хүүгийн авлага 0.3 сая төгрөгийг арилжааны банктай тооцоо нийлээгүй урьдчилж орсон орлого дансыг бууруулж бүртгэсэн.
- Тайлант хугацаанд акталсан 245 нэр төрлийн 43.6 сая төгрөгийн бараа материалыг санхүү, татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүгээр тайлагнаагүй нийт 43.9 сая төгрөг алдаа илэрснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 15 дугаар зүйлийн 15.2 "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтуудыг үндэслэн залруулсан.

Аудитаар нийт 5.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 3.2 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 2 албан шаардлага хүргүүлж, 1.9 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 5.1 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 24.3 сая төгрөгөөс бага боловч газрын тосны бүтээгдэхүүн худалдах, худалдан авах тухай гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулаагүй зөрчил нь шинж чанарын хувьд материаллаг байгаа тул "Хязгаарпалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Сахилгын шийтгэл давтан гаргасан нэр бүхий ажилтанд 3.0 сая төгрөгийн шагнал олгохдоо захирлын зөвлөлийн хурлаар шийдвэрлээгүй байна.

Эн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах". Байгууллагын дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.2.8 "Байгууллагад онцгой ашиг оруулсан, зардал хэмнэсэн, бизнесийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан ажилтанд тухайн үр дүнгийн хэмжээ болон бүтээмжээс хамааран үр дүнгийн шагнал олгож болно. Үр дүнгийн шагнал олгох, шагналын хэмжээг тогтоох асуудлыг захирлын зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Захирлын зөвлөлийн шийдвэргүйгээр шагнал олгосон зөрчилд буурутай албан тушаалтнаар төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

2. Гадаад томилолттой байх хугацаанд нэр бүхий 7 ажилтанд хоолны мөнгө 0.2 сая төгрөг олгосон байна.

Эн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 "Үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтыг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "үр ашигтай байх", 4.2.9 "энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтын хугацаанд хоолны мөнгө олгосон зөрчилд буурутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Шунхлай петролиум ХХК нь Газрын тосны бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээний дагуу 2,239.3 сая төгрөгийн бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний үүргээ хэсэгчилсэн дүнгээр Шунхлай трейдинг ХХК-аар дамжуулан нийлүүлсэн байна.

Эн нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 "Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний

үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно", 40.2.2 "гүйцэтгэгч гэрээний үүргийг
туравдагч этгээдэд шилжүүлэх", 48 дугаар зүйлийн 48.2.11 "гэрээнд заасан нөхцөлийн дагуу
төлбөр тооцоог гүйцэтгэх", Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн
20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө
хянан, баталгаажуулах" Газрын тосны бүтээгдэхүүн худалдан авах тухай
ШТШАБ/20240102071 дүгээр гэрээний 2-т "Гэрээний үнийг нийлүүлэгч "Шунхтай
петролиум" ХХК-ийн харилцах ХААН банкны 5038026962 дугаар дансанд шилжүүлэх" гэж
тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ
худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох
албан шаардлага хүргүүлсэн.

2. Газрын тосны бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээний дагуу Би энд Юу Майн ХХК
нь 1,169.6 сая төгрөгийн 0.4 сая литр дизель түлш худалдан авах тухай гэрээ байгуулж, акт
үйлдсэн боловч борлуулалтын төлбөрийг Нефть проект ХХК-аар гүйцэтгүүлж, цахим
төлбөрийн и баримт шивж баталгаажуулсан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 "Татвар төлөгч борлуулалт хийх
тухай бурд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг
хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай
хуулийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2 "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай
бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.5 "Албан татвар суутган төлөгч
төлбөрийн баримт олгохоос татгалзах, хуурамч буюу хийгдсэн төлбөр тооцоонос өөр
дүнтэй төлбөрийн баримт олгохыг хориглоно", Газрын тосны бүтээгдэхүүн худалдах,
худалдан авах ШТШАБ/2024-18 дугаар гэрээний 6 дугаар зүйлийн 6.2.1 "худалдан авагч уг
гэрээний хүчин төгөлдөр хугацаанд худалдагчид цаг тухайдаа шатахууны төлбөрөө төлөх
үүрэг хүлээж, гэрээнд заасан хугацаанд шатахууны төлбөрийг 3.3-т заасны дагуу төлнө",
Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба
төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус
тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Газрын тосны бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээний үүргээ
зөрчиж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн
харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны бүрдэл дутуу баримтаар салбарын тэмцээний зардалд 1.9 сая
төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж,
байгууллагын удирдлага нь нягтлан бodoх бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм,
журам, зааварт нийцүүлэн нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж,
мердөж ажиллана." гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд
зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа, ажил үйлчилгээний төлбөрийг шилжүүлэхдээ анхан шатны
баримтын иж бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 01-
ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал
илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайллангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа				Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан				Буруу тусган илэрхийлсэн				Үүнээс				/мянган төгрөгөөр/	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж	Дүн		
Арилжяаны банкны хадгаламжийн хүүгийн авлага 0.3 сая төгрөгийг арилжааны банктай тооцоо нийлээгүй үрьдчилж орсон орлого дансыг бууруулж бүртгэсэн байна.	1	297.0	-	-	-	-	-	-	1	297.0	-	-	-	-	-	-		
Тайлант хугацаанд актапсан 245 нэр төрийн 43.6 сая төгрөгийн бараа материалыг санхүү. татварын тайллангийн үзүүлэлт хоорондын зөргүүзэр тайлагнаагүй байна.	1	43,630.4	-	-	-	-	-	-	1	43,630.4	-	-	-	-	-	-		
Дүн	2	43,927.4	-	-	-	-	-	-	2	43,927.4	-	-	-	-	-	-		

Санхүүгийн тайллангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Төлбөрийн акт				Албан шаардлага				Үүнээс				/мянган төгрөгөөр/	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Албан тушаалтны тоо	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	Тоо	Дүн	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	Тоо	Дүн	
Салбарын тэмцээний зардалд зарцуулсан 1.9 сая төгрөг нь анхан шатны нотлох баримтын бурдэг дутту байна.	1	1,900.0	-	-	-	-	-	-	1	1,900.0	-	-	-	-	-	-	-	
Сахилгын шийтгэл 2 удаа авсан нэр бүхий ажилтанд 3.0 сая төгрөгийн шатнаал олгоходоо захирлын зөвлөлийн хурлаар шийдвэрлээгүй байна.	1	3,000.0	1	3,000.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	

Шингэн тупш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчтөг аж ахуйн тооцоот уйлдвэрийн
Газарын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Гадаад томилолтой байх хугацаанд нэр бүхий 7 ажилтанд хоолны мөнгө 0.2 сая төгрөг олгосон	1	168.0	1	168.0	-	-	-	-	-	-	-
Шунхлай петролиум ХХК нь Газрын тосны бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээний дагуу 2,239.3 сая төгрөгийн бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний Ургээ биелүүлээгүй, Шунхлай ХХК-аар дамжуулан нийлүүлсэн байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-
Газрын тосны бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээний дагуу Би энд юу майн ХХК нь 1,169.6 сая төгрөгийн 0.4 сая литр дизель тулш худалдан авах тухай гэрээ байгуулж, акт Үйлдсэн боловч борлуулалтын төлбөрийг Нефтьт проект ХХК-аар гүйцэтгүүлж, Чахим төлбөрийн и баримт шивж баталгаажуулсан байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-
Дүн	5	5,068.0	2	3,168.0	2	-	1	1,900.0	-	-	-

Санхүүгийн тайланийн аудитаар шалгасан нийтийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил			Үүнээс			/Мянган төгрөгөөр/
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэй холбоотой зөрчил							
Шилэн дансны цахим хуудаст нийт 127,779.8 сая төгрөгийн 249 мэдээлэл байршуулахаас орлогын 50.6 сая төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй байна.	1	50,585.2			1	50,585.2	
Дүн	1	50,585.2			1	50,585.2	

01

ТОРИЙН АУДИТИН БАЙГУУЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДУТНЭЛТ



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2025 оны 03 дугаар сарын 14

№ 133/20150458
снаг-2025/06/1/на-стя-тогт

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Сахилгын шийтгэл давтан гаргасан нэр бүхий ажилтанд 3,000,000.00 /гурван сая/ төгрөгийн шагнал олгоходоо захирлын зөвлөлийн хурлаар шийдвэрлэгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.2.8-д хувь нэмэр оруулсан ажилтанд тухайн үр дүнгийн хэмжээ болон бүтээмжээс хамааран үр дүнгийн шагнал олгож болно. Үр дүнгийн шагнал олгох, шагналын хэмжээг тогтоох асуудлыг захирлын зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны A/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д, заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Захирлын зөвлөлийн шийдвэрлгүйгээр олгосон 3,000,000.00 /гурван сая/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын захирал /Г.Гансүх/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Дэлгэрдалай/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МАЙЦЭЦЭГ



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2025 оны 03 дугаар сарын 14 № 134/2050458
Сийлт 2025/061/на-ст-пчг

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үнд:

Гадаад томилолтой байх хугацаанд нэр бүхий 7 ажилтанд хоолны мөнгө 168,000.00 /нэг зуун жаран найман мянган/ төгрөг олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-д "Үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтыг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "унэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Үр ашигтай байх", 4.2.9-д "Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх", гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бурдуулэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3 "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

- Томилолтын хугацаанд олгосон хоолны мөнгө 168,000.00 /нэг зуун жаран найман мянган/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дах Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын захирал /Г.Гансүх/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Дэлгэрдалай/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МАЙЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Akt\2025\0314\SNAG-9.Docx

ДТА9893 ЧС 09
2023031553



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 493/00150458

Улаанбаатар хот

Сэргэлжүүлэх 2025/06/1/наа-сэх-поцг

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын тосны бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээний дагуу Би энд Юу Майн ХХК нь 1,169,578,800.00 /Нэг тэрбум нэг зуун жаран есөн сая таван зуун далан найман мянган найман зуун/ төгрөгийн 436,410 /дөрвөн зуун гучин зургаан мянга дөрвөн зуун арван/ литр дизель түлш худалдан авах тухай гэрээ байгуулж, акт үйлдсэн боловч борлуулалтын төлбөрийг Нефть проект ХХК-аар гүйцэтгүүлж, цахим төлбөрийн и баримт шивж баталгаажуулсан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй", НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.5 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримт олгохоос татгалзах, хуурамч буюу хийгдсэн төлбөр тооцоноос өөр дүнтэй төлбөрийн баримт олгохыг хориглоно". Газрын тосны бүтээгдэхүүн худалдах, худалдан авах ШТШАБ/2024-18 дугаар гэрээний 6 дугаар зүйлийн 6.2.1 "худалдан авагч уг гэрээний хүчин төгөлдөр хугацаанд худалдагчид цаг тухайдаа шатахууны төлбөрөө төлөх үүрэг хүлээж, гэрээнд заасан хугацаанд шатахууны төлбөрийг 3.3-т заасны дагуу төлнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хулээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гож үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

- Газрын тосны бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээний үүргээ зөрчиж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ируулэх;
- Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын захирал /Г.Гансух/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Дэлгэрдалай/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Д.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МАЙЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй оүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z: Alban Shaardlaga 2025/03/14 SNAC-16.Docx

АТААЛАЗ 91-5109
9023030583



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 494/0050458
Санкт- 2025/061 на- СНГ- точг

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шунхлай петролиум ХХК нь Газрын тосны бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээний дагуу 2,239,289,500.00 /хоёр тэрбум хоёр зуун гучин есөн сая хоёр зуун наян есөн мянга таван зуун/ төгрөгийн бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний үүргээ хэсэгчилсэн дүнгээр Шунхлай трейдинг ХХК-аар дамжуулан нийлүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т "Худалдан авах гэрээ болон өрөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно", 40.2.2-т "гүйцэтгэгч гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэх", 48 дугаар зүйлийн 48.2.11-д "гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр тооцоог гүйцэтгэх", Нягтлан бодох буртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" Газрын тосны бүтээгдэхүүн худалдан авах тухай ШТШАБ/20240102071 дугаар гэрээний 2-т "Гэрээний унийг Нийлүүлэгч "Шунхлай петролиум" ХХК-ийн харилцах ХААН банкны 5038026962 дугаар дансанд шилжүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захирагааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан ўргээ билээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын захирал /Г.Гансүх/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Дэлгэрдалай/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МАЙЦЭЦЭГ

ТЭМДЭГЛЭЛ

Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр

Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг

Улаанбаатар-15160, Монгол Улс